

ЛЯО УЛСЫН ҮЕИЙН УРИАНХАЙЧУУДЫН ҮҮСЭЛ ГАРАЛ

БАЙ. БАЯНТАЛ

*БНХАУ-ын Хөлөнбуйр дээд сургуулийн Аялал жуулчлал, Газарзүй,
Түүх соёлын сургуулийн багш, доктор
baibayintala@163.com*

Товч агуулга. Урианхай аймаг нь Монголын түүхийн хөгжлийн явцад их нөлөө үзүүлсэн аймаг болно. Тус аймаг нь Ляо улсын үед нэлээд томоохон болж, Волянгай улсын (wolangganai 鞞朗改) ба Ванянгай овог (wanianggai 嵬娘改) гэж хоёр хэсэг хуваагджээ. Их Монгол Улс, Юань улсын үед Урианхай, Ойн Урианхай (huaiyin 槐因) гэж нэрлэгдэж байсан хоёр аймаг нь Юань улсын дараа үед зүүн баруун таван түмэнд хуваагдах болсон. Хубилай хааны үеэс Юань улсын гучдугаар он болтол Тогтобухад дайлагдсан Тува, Ойн Урианхай зэрэг таван аймаг Хянгана давааны өмнөд хэсэгт нүүдэллэн ирж Мин улсын эхэн үед Хянганаас урагш оршин сууж байсан Урианхайн гурван харуул (Доён гурван харуул) (duoyanwuliangha 朵颜兀良哈) мандаж, бүх Ляо гол (liaohe 辽河)-ын дунд, дээд сав газрын эзлэн авч, Цахар түмэн зүүн гурван түмнээ дагуулан өмнөш түрсний дараа Урианхайн гурван харуул (wulianghasanwei 兀良哈三卫) зүүн гурван түмэнд хуваагдаж хэсэг Урианхайчууд баруун тийш нүүж Түмэдийн Алтан хаанд түшжээ. Чин гүрний дотоод засгийн Монгол зургаан чуулганы нэг Зостын чуулганы таван хошуунд Харчин гурван хошуу, Түмэдийн зүүн гарын хошууны язгууртад бүр монгол Урианхай овгийн бөлгөө. Маш олон түүх тэмдэглэлд тэдний өвөг дээдэс нь Их Монгол улсын Чингис хааны дөрвөн нохойн нэг болох Зэлмэ болох тухай тэмдэглэн тодорхойлсон байдаг. Үүнийг дахин нуршихгүй. Тус өгүүлэлд голдуу Урианхай овгийн гарлын тухай тодорхойлон тодорхойлохыг хичээв.

Түлхүүр үг: *Урианхай түмэн, доён урианхай*

Keywords: *The people of Uriankhai, the people of Doyan Uriankhai*

(Тус өгүүлэл нь ӨМӨЗО-ны Боловсролын газраас дэмжин хэрэгжүүлж буй Орон нутгийн их, дээд сургуулийн шинэчлэл, хөгжлийн сан (Шинжлэх ухааны бүтээн байгуулалт)-гийн төслийн 2024 оны судалгааны үр дүн болно. “Умард хязгаарын соёлын бүтээн байгуулалтын онолын судалгааны төсөл”. 2023.11.23)

ЛЯО УЛСЫН ҮЕИЙН УРИАНХАЙ УЛС БОЛОН УРИАНХАЙ ОВГИЙН АЙМАГ

“Ляо улсын бичиг”-т Воланхай (wolangganai 斡朗改) болон Ваняньхай (wanianggai 温娘改) зэрэг Ляо улсын харьяат улсын вангийн ордны болон аймгийн нэрийдэл олонтоо дурдагддаг. Зохиогчоос эдгээр нэрийдэл бол дуудлага өөрчлөгдсөн монгол нэрийдэл мөн хэмээн төсөөлж буй. Жишээлбэл, “Ляо улсын бичиг”-ийн нэгдүгээр ботийн “Тайзугийн уг тэмдэглэл”-д “... гуравдугаар оны аравдугаар сард (өвлийн тэргүүн сард) Яин Жиоюн нэрт цэргийг илгээж Хар тэрэгт (heichezi 黑车子) Шивэй (shiwei 室韦) улсыг дайлаад авч ирлээ. Түүний баруун хойнох Нянхай аймаг тэрэгч эрсийг нийлүүлэв”¹ хэмээжээ. Мөн жаран есдүгээр ботийн хүснэгт долоод “Хар тэрэгт Шивэй улсыг дайлаад авч ирлээ. Түүнээс баруун хойнох Ваняньхай аймаг тэрэгч эрсийг нийлүүлэв”² гэж адилхан агуулгыг тэмдэглэжээ. Маш тодорхой нэгэн зүйл бол энд дурдан буй Ваняньхай аймаг бол Хар тэрэгт (heichezi 黑车子) Шивэйгийн зэргэлдээ оршин суугч баруун хойдын аймаг угсаа болох мөртөө “түүнээс баруун хойнох Ваняньхай аймаг тэрэгч эрсийг нийлүүлэв” хэмээн өгүүлж байгаа нь үнэн хэрэгтээ Ляо улсын цэрэг олзолж авчраад цана (chana 察纳) зэргийг хөллүүлж Хятан цэргийн байлдааны хэрэгсэл тээвэрлүүлж байсан Нянхай аймгийн анчдыг зааж буй ажээ. Учир нь, Хятан угсаатан өөрөө нүүдэлчин малчин үндэстэн, тэдэнд өөрт нь морин тэрэг хөтлөх тэрэгч хүмүүс дутахааргүй. Говийн ард өвлийн улирал болж (тус үйл явдал нь өвлийн улирал аравдугаар сард эхэлсэн) цас мөсөнд хучигдаж, морин тэрэгт эд бараагаа ачихад хүндрэлтэй болжээ. Харин ойн Урианхайчууд хөр цаст аглаг ойд ангуучилж цанаар эд бараа зөөвөрлөхдөө маш чадамгай байдаг. Д’Оссоны (duosan 多桑) Монголын түүхийг үндэслэвэл, “Урианхай аймгийн харьяат нутаг нь уул бартаа үргэлжилж, ой хөвчид бүрхэгдсэн, цаг агаар хахир хүйтэн, өвлийн улиралд ой хөвчид агнахдаа цана гэх гулгуур хавтсыг хөлдөө уяж, гартаа тулгуур мод барьж сал завь усанд сэлэх мэт урагшилдаг. Дээш газар урагшлах буюу өгсөж уруудах нь түргэн гавшгай, ангуучилж явахад ан амьтныг амархан олзолж чаддаг. Агнаж олсон ангийн олзоо ардаа чирч явдаг чаргадаа ачдаг. Чарга бүр бараг хоёр гурван мянган мин (нэг мин нь 2 жинтэй тэнцэх хүнд) бараа ачдаг. Цаныг хэрэглэж чаддаггүй нэгэн нь хөлөө гэмтээх аюултай. Мөн уул даваа уруудахад маш аюултай”³ гэжээ. Эсвэл хахир хүйтэн өвлийн алс холын баруун хойдын аймаг угсаа учир шалтгаангүйгээр мянган газрын алсад бодолгүй сайн дураар Ляо улсын хааны тэрэгч эрсийг нийлүүлэх гэгч мөн ёсонд нийцэхээр барагтай аж.

¹ 《辽史》(liaoshi), 第一卷, 《太祖本纪》, 4页.

² 《辽史》(liaoshi), 第六十九卷, 表七. 1079页.

³ 多桑蒙古史》(Д’Оссон монгол түүх), 冯承钧译, 上海书店出版社, 2001年, 第一版, p.158~159

“Shuowen jiezi说文解字”, “kangxi zidian康熙字典”, “wangli guhanyuzidian 王力古汉语字典” зэрэг толь бичигт “挽 (wan) үсгийн утга нь “цэргийн” буюу “татах”⁴ гэж тайлбарлажээ.

“Ляо улсын түүх”-ийн 116 дугаар дэвтэр “Үгсийн тайлбар”⁵ (guoyujie国语解)-д “Ванянхай (wanianggai媿娘改)”-г “Газрын нэрийн бүлэг”-т оруулжээ. Эндээс үзвэл, “Ванянхай (wanianggai媿娘改)” нь улсын нэр биш, харин газар орны нэрийдэл буюу аймаг угсааны нэр болно. “Ляо улсын түүх”-д “Ванянхай (wanianggai媿娘改)”-ийн тухай энэ ганцхан мэдээнээс үзвэл тэд ерийн үед Ляо гүрэнтэй төдийлөн харилцаа холбоогүй байсан нь харагдана.

“Ляо улсын түүх”-д тэмдэглэгдсэн өөр нэгэн “Воланхай (wolanggai斡朗改-)” нь харин Ляо улсын харьяат улсын байр суурьтай болох нь харагддаг. “Ляо улсын түүх” 46 дугаар дэвтэрт “Ноёдын хураангуй (baiguanzhi 百官志-)”-ийн умардын харьяат улсын жагсаалтад “Воланхай улсын Вангийн ордон (wolanggai guowangfu 斡朗-改国王府)”⁶ хэмээн тэмдэглэснээс ингэж үзэж болохоор байна.

“Воланхай улсын Вангийн ордон (wolanggai guowangfu斡郎改国王府)” нь харин дээр дурдсан “Ванянхай (wanianggai媿娘改-) аймаг”-тай адилгүй. Тэд Ляо гүрний төвийн захиргаатай маш нягт харилцаатай байжээ. “Ляо улсын түүх” 6 дугаар дэвтэр “Мүзун хааны уг тэмдэглэл (muzong benji 穆宗本纪)”-д тэмдэглэсэн нь арван гурван оны арван сар, Воланхай улсын нийлүүлсэн хүдрийн заарыг байцаан үзэв⁷ хэмээжээ.

“Ляо улсын түүх” боть 27, уг тэмдэглэлийн 27 “Тянь Зо хуанди Елюй Яньси (tianzuohuangdi Yeluyanxi天祚皇帝耶律延禧-)-д “Циян Түнгийн гуравдугаар оны зургаадугаар сар, Воланхай улс элчин илгээж сайн тайга нохдыг нийлүүлэв”⁸ гэжээ.

“Ляо улсын түүх” боть 36, “Цэрэг хуягийн тэмдэглэл (binweizhi兵卫志)” харьяат улсын цэргийн зурваст Воланхай (wolanggai斡朗改-)ын нэр буй. Бас тэмдэглэсэн нь “Ляо гүрний харьяат улс 59 буй. Төрд (chao朝) алба барих (gong贡) нь тогтсон зүйл үгүй. Учир явдалтай болбоос элч илгээж дайчилмуй. Эсвэл жуу бичгийг буулгуулмуй. Зарлиг эс дагаваас дайлмуй. Туслах цэргийн олон цөөхөн нь өөрийн дур, тогтсон тоогүй” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Энэ тухай Цянь Да Шэний (qiandaxin钱大昕) харгуулан бичсэнээс лавлаж болно. Воланхай, Ванянхай гэх нэр тус номонд олонтоо тохиох бөгөөд нэгийг нь харьяат улсын, нөгөөг нь аймаг угсааны нэрээр тэмдэглэжээ. Люй Ши Пей (liushipei刘师培)-ийн “Зүүн өргөөний түүвэр”-ийн 5 дугаар ботийн

⁴ 说文解字》(Хятад үсгийн тайлбар), [汉]许慎 撰, 中华书局影印, 1963年, 第一版。 251页 《康熙字典》, [清]张玉书 主编, 天津古籍出版社, 1995年, 第一版。 139页 《王力古汉语字典》, 中华书局, 2000年, 第一版。 369页.

⁵ 《辽史》(liaoshi), 第一百一十六卷, 《国语解》。1535页.

⁶ 《辽史》(liaoshi), 第四十六卷, 《百官志》。759页.

⁷ 《辽史》(liaoshi), 第六卷, 《穆宗本纪》。78页.

⁸ 《辽史》(liaoshi), 第二十七卷, 《天祚皇帝耶律延禧一》。327页.

⁹ 《辽史》(liaoshi), 第三十六卷, 《兵卫志》属国兵条。429页

аймаг угсаатны хүснэгтийн ард бүр Урианхайн аялгуу хуваасан дуудлага гэж тэмдэглэжээ. “Юань улсын түүх”-д Улянхэ (wulianghe兀良合-) гэжээ¹⁰.

Ляо гүрний сүүлчийн үед Елюй Даши нь Төв Ази тийш цэрэглэхдээ говийн ард түр саатсан талаарх Ляо улсын түүхийн тэмдэглэлийг нарийвчлан шинжилбэл, тэрээр энэ удаад Волянхай улс буюу Ваняньхай аймаг зэрэг ойн иргэдийг эзэгнэснгүй. “Тяньзо Боюэ дутаасан (tianzuoboюуе天祚播越) Елюй Даши нь Яньжин Го ван Чүн (yanjin guowangchun燕晋国王淳) Шоуфейг (萧妃) Тяньдэ (tiande天德)-д цаазалж, Дашигаас (dashi大石) ял асуув. Даши олноо дагуулан баруунш одож өөрийгөө хаан хэмээн өргөмжлөв. Явж өнгөрсөн олон аймаг нь доорх мэт”¹¹ гэжээ.

Их шар шивэй аймаг 大黄室韦部	Цагаан татар аймаг 白达旦部	Дилар аймаг 敌烈部	Хонгирайд аймаг 王纪 刺部
Цасла аймаг 茶赤刺部	Яши аймаг 也喜部	Битүд аймаг 鼻骨德部	Нилан аймаг 尼刺部
Далагуй аймаг 达刺乖部	Тамил аймаг 达密里部	Мэргэд аймаг 密儿纪部	Хазэг аймаг 合主部
Үхүл аймаг 乌古里部	Зүбэр аймаг 阻卜部	Босгуун аймаг 普速完部	Тангуд аймаг 唐古部
Хүмүси аймаг 忽母思部	Шидэ аймаг 奚的部	Жарби аймаг 纪而毕部	Найман аймаг 乃蛮部
Уйгур Даши аймаг 回回大食部	Шинсаганы орон 寻思干地	Чармана орон 起而漫地	Уйгур хот 畏吾儿城

Дээрх тэмдэглэлээс үзвэл Елюй Дашигийн замд дайрсан говийн арын арван найман аймгийн дотор Волянхай (-wolangganai斡朗改) буюу Ваняньхай (waniangganai 唃娘改-) зэрэг ойн иргэд багтсангүй. Гэвч энэ нь Урианхай аймгийн нэг улсын нэг аймаг оршихгүй гэсэн явдал биш зөвхөн Елюй Даши тэдэнтэй уулзсангүй буюу зам дагуу дайрсангүй гэсэн явдал мөн.

Энэ бүгдээс үзвэл, Ляо гүрний үед говийн арын Урианхай аймаг нь аль эрт түүх сурвалжид тэмдэглэгдсэн бөгөөд бас нэг улс, нэг аймаг гэсэн хоёр Урианхай тэмдэглэгдэж байжээ. Үүнд Волянхай улс нь Ляо гүрэнтэй харьяат улсын харьцаатай байхад Ваняньхай аймаг нь Ляо гүрэнтэй харьцаа холбоо сул нэлээд зайдуу, зөвхөн нэг удаагийн дайн тулаанаас бусад үед Ляо гүрэнтэй ямар ч харилцаа холбоогүй байжээ. “Ляо улсын түүх”-ийн “Үгсийн тайлбар” (guoyujie 国语解)-г тэмдэглэснийг үндэслэвэл “Ваняньхай аймаг (waniangganai buzhu唃娘改部族-)” бол газрын нэр болно. “Баруун хойдын угсаа аймаг Тагна (tangnu wuigianhai 兀良哈) урианхай аймаг угсаа”. Энэ нь хүмүүст Монголын өндөрлөгийн баруун хойдын нэгэн аймаг угсааг аяндаа санагдуулна. Тэр нь даруй Тагна урианхай болно.

¹⁰ 《辽史》(liaoshi), 钱大昕校刊本。435页.

¹¹ 《辽史》(liaoshi), 第六十九卷, 《嚩族表》。1123页.

ИХ МОНГОЛ УЛС БА ЮАНИЙ ҮЕИЙН “УРИАНХАЙ” БОЛОН “ОЙН УРИАНХАЙ”

XIII зуунаас хойш Урианхай аймгийн түүхэн ул мөр бага багаар тодорхой болж, сурвалж бичигт тэмдэглэгдэх болсноос Судрын чуулганд Урианхай аймгийн түүхийг харьцангуй бүрэн бүтэн тэмдэглэсэн байна. Судрын чуулганы мэдээг үндэслэвэл тухайн үеийн Урианхай нь “Ойн иргэн Урианхайчууд” болон “Дарлигин Урианхайчууд” гэсэн хоёр хэсгээс бүрэлдэнэ. Үүний тэмдэглэл нь хэдийгээр хожмын эрдэмтдийн анхааралд өртсөн боловч “Ляо улсын түүх”-д тэмдэглэсэнтэй яв цав нийцсэн байдаг. Урианхай аймгийн түүхэн хөгжилтийн ул мөр мөн ч үүнтэй нийцэж буй ажээ. Иймээс зохиогч мөн Судрын чуулганд тэмдэглэсэн Урианхай аймгийн түүх нь үнэн зүйл гэж үзэж буй.

Бид урьдаар Рашид Ад Дины тэмдэглэлийн Дарлигин Монгол гаралтай Урианхай аймгийн тухай нарийвчилбаас тус аймгаас хоёр түүхийн алдарт хүн гарсан нь Сүбэдэй баатар болон Зэлмэ болно.

“Юань улсын түүх” боть 121, намтар түүхийн наймдугаар зурваст “Сүбэдэй Урианхай аймгийн хүн. Түүний дээдэс Онон мөрөнд авлахуйд Тумбанай лугаа уулзаж анд бололцов. Тайзугийн үе хүртэл таван үе болжээ. Гуравдугаар үе нь Хачиуд, хөвгүүн Хабан, Хабан хоёр хөвүүнтэй. Их нь Хулхад, бага нь Сүбэдэй. Эрэлхэг зоригтой, харвах намнахад гарамгай”¹² гэжээ. Эндээс үзвэл, Сүбэдэйн дээдэс үе улиран Бурхан Халдунд нутаглаж байсан гэж хэлж болох аж. Бас “Монголын түүхийн тэмдэглэл” (mengwuershi蒙兀儿史)-ийн 29-р боть “Зэлмийн намтар”-г “Зэлмэ, Жарчиудай Урианхай аймгийн хүн. Эцэг нь Жарчиудай өвгөн, төмрийн дархан. Бурхан Халдуны энгэрт нутаглаж, Чингис хааны эцэг Есүхэйтэй анд, Чингис хааныг мэндлэхэд Жарчиудай хүрэлцэн ирж баяр хүргэж булган манцуй бэлэглэв”¹³. Дээрх тэмдэглэлийг үндэслэвэл Сүбэдэй, Зэлмэ хоёр бүр Бурхан Халдуны Урианхай аймгийн хүн болох нь зайлшгүй ажээ.

Бурхан Халдуны Урианхай аймгийн тухай “Судрын чуулган”-д “Тус аймаг нь Хиад ба Никус овгоос гаралтай. Өөр нэгэн аймаг хүмүүс нь “Ойн Урианхай”¹⁴ гэдэг. Гэвч Ойн Урианхай нь эднүүстэй адилгүй. Ойн Урианхайчууд Баргужин төхөмд нутаглаж тэнд бас Хорь, Баргужин, Түмэд зэрэг аймаг нутаглаж тэдний аймаг угсаа болон салбар сэлтэр нь монголтой адилгүй” гэжээ. Энд Рашид тэдний оршин амьдарч буй нутаг ус болон аймаг угсааны үүсэл гарлыг тодорхой зааж гаргажээ. Урианхайчууд үе улиран Монголын өндөрлөгийн хүйс болох Хэнтий нурууны энгэр, өврөөр нутаглаж, эдгээр хүмүүс нь ойн иргэдийн амьдралын заншлаа хэсэг хэмжээнд хадгалж, бас эсгий туургатны хэсэг хэмжээний онцлогтой байдаг. Чингис хааны дээдсийн үеэс Бурхан Халдуны Урианхайчууд

¹² 《元史》(Юань улсын түүх), 中华书局, 1976年, 第一版重印本, 第一百二十一卷, 《速不台传》。P.2975

¹³ 《蒙兀儿史记》(Монголын түүхийн тэмдэглэл), 屠寄 著, 线装本影印版, 第二十九卷, 《者勒蔑传》。P.284

¹⁴ 《史集》(Судрын чуулган), 拉施德 著, 余大钧 译, 商务印书馆, 1983年, 第一版, 第一卷, 第一分册, P.255。

тэдний Хиад аймагтай салахын аргагүй холбоотой байжээ. Энэ тухай “Монголын Нууц Товчоо”-д маш нарийн тэмдэглэсэн байдаг. Энд дахин нуршихгүй.

Чингис хаан Монгол туургатныг нэгтгэж Их Монгол улсыг байгуулсны дараа 95 мянган хуваахад Бурхан Халдуны Урианхай гурван мянган болжээ. Нэгдүгээрт Алчигудайн Урианхайн мянган, “Судрын чуулган”-д “Чингис цэргээ хуваахад Алчигудай ноёнд гурван мянгыг өгөв. ... Энэ гурван мянгад Найман, Урианхай, Татар багтжээ”¹⁵ гэжээ. Алчигудайгийн Урианхай мянганы ноён нь Зэлмийн дүү Цуурхай (chawueraizhuan察兀儿孩传) ноён. “Монголын түүхийн тэмдэглэл” боть 28 “Цуурхайн намтар”-т “Цуурхай улсад байгуулсан гавьяагаар тавин наймдугаар нэрс. Зүүн гарын мянганыг өвлөжээ. Чингис хааны дүү Хачигуны хөвгүүн Алчигудайн харьяат мөн өөрийн харьяат Урианхай иргэн хоёр мянганыг удирдав”¹⁶. Найман мянганы ноён нь Найман аймгийн хүн Хачигун юм. Хоёрдугаар Урианхай аймаг нь Зэлмийн харьяат Урианхайн мянган болно. Учир нь Их Монгол улс байгуулагдахаас өмнө Зэлмийн харьяат Урианхай хүмүүс маш олон байжээ. Сүбэдэй ноён хүртэл анх Чингис хаанд түшээ ирэхдээ Зэлмийн харьяат болсон байдаг (Нууц Товчооны 120-р зүйл). Тус Урианхай мянган нь хожим Зэлмийн хөвгүүн Есөнтөөгийн харьяат болж Есөнтөө нас барсны сүүлээр хөвгүүн Буха залгамжилжээ. Сүбэдэйн харьяат мянган нь цул Урианхай аймаг биш. “Нууц Товчоон”-д “Чингис хаан Зэв, Сүбэдэй хоёрт өөрийн иргэдийг мянгат болгон удирд гэж зарлиг болов”¹⁷ гэж буй. Яриангүй Сүбэдэйн мянганд олонх нь бүр Урианхай гаралтай хүмүүс гэвч бас бусад аймаг угсааны хүмүүс байдаг байжээ. Жишээлбэл, Бурхан Халдунд нутаглаж байсан Урианхай аймаг нь Их Монгол улс байгуулагдсаны дараа Зэлмийн Урианхай мянган болжээ. Цуурхайн (chawuerhai察兀儿孩) Урианхайн мянган (хоёр мянга, түүнд нэг мянган нь татар зэрэг бусад аймаг угсаагаар бүрдүүлжээ) Сүбэдэйн харьяат мянганы хэсэг Урианхай зэрэг гурван мянга хүрэхгүй өрх багталцдаг.

Эдгээр Урианхай нь алтан ургаар ахлуулсан эздээ дагаж шинэ эзэмшилд нүүдэллэж арван нэгдүгээр зуунаас нааш нутаглаж ирсэн Бурхан Халдунаасаа нүүж, харин тэдний оронд “Ойн Урианхай” нь Бурхан Халдунд нутаглан суужээ¹⁸.

Рашидын тэмдэглэснийг үндэслэвэл “Ойн Урианхай” уул нь Баргужин Төхөмд ангуучилж байжээ. Тэндэх Хорь, Баргужин, Түмэд аймагтай ойролцоо нутаглаж байв. Ерөөс ой хөвчөөс салдаггүй. Гаднах ертөнцөөс ангид ой хөвчийн “зол жаргалт” амьдрал хийж байжээ. Тэд тал нутгийн “Эсгий туургатан” иргэдийг гадуурхан үздэг. Бурхан Халдунд нүүдэллэн ирсний дараа мөн маш урт удаан хугацаанд энэхүү уламжлалаа хадгалж байв. “Судрын чуулган”-д “Энэхүү Удач овог нь энгийн боол угсаанаасаа болж эртнээс охиноо гаднах

¹⁵ 《史集》(Судрын чуулган), 第一卷第二分册, P.379

¹⁶ 《蒙兀儿史记》, 第二十八卷, 《察兀儿孩传》。P.280

¹⁷ 《蒙古秘史》(Монголын нууц товчоо), 四部丛刊三编本, 第 221 节。

¹⁸ 《蒙兀儿史记》, 第二十八卷, 《察兀儿孩传》。P.285

овогт харьцуулдаггүй. Мөн ч харь овгоос буулгадаггүй”¹⁹ гэжээ. Үнэндээ Рашид Ад Дин хэрэг учрын шалтгааныг “Боол угсаа”-аас шалтгаалсан ураг хуримын заншил гэдэгт эндүү тохжээ. Энэ нь “Судрын чуулган”-ы өөр нэгэн зурвастай мөн харьцаа холбоотой байдаг. “Тэд (Ойн Урианхай) хоньчдыг маш голдог. Эцэг эх нь охиноо хараахдаа (чамайг хоньчинд өгч хонь хариулгуулсугай) гэдэг байв. Тэгвээс охин нь машид гутран зовж заримдаа биеэ егүүтгэхэд ч хүрдэг.”²⁰ гэжээ. Энэ бол сая үнэн шалтгаан нь мөн ажээ.

Дахин өгүүлэхэд “Ойн Урианхай” гэдэг нь хоёр зүйлийн утгатай байж, явцуу утгаараа “Ойн Урианхай” нь нэг хэсэг анчин, гөрөөчин угсаатныхныг зааж буй. Харин дэлгэрэнгүй утгаараа бол “Ойн Урианхай” гэдэг нь монголч тухайн үеийн бүхий л аймаг угсааг нэрлэсэн үг болох юм. Шинжилгээнийхэн хэлдэг “Ойн Иргэд”-тэй утга нэг үг болно. Тэрчлэн “Ойрад” ч ийм утгаар хэрэглэгдэж байжээ.

Чингис хааны төр байгуулсан наян найман гавьяатдын дөчин есдүгээрт жагсдаг нэгэн бол мянганы ноён Одтой гэгч билээ. Тус хүн нь Ойн Урианхайн Удач мянганы ноён гэх магадлал өндөр байна.

“Судрын чуулган”-д “Аймгийн ойн иргэдийн Удач мянган, засаг ба заншил ёсоор энэхүү аймаг болон Удач мянганы хойчис өөрийн харьяат иргэдийн хамт Бурхан Халдунд орших дээдсийн онгоны хориг газрыг дархлан сахиж үүрд дайтахгүй”²¹ гэжээ. Үүнээс үзэж гарах нь “Ойн Урианхайд” мянган нь тал нутгийн амьдралд зохихгүй. Чингис хаан мөн өөрийн хойчийн явдлын тухай бодолхийлж, Ойн Урианхайдаар дээдсийн хориг орныг сахиулахаар болсон нь аль алинд нь ашигтай ажээ. Тиймийн тул өөрийн амьд бүхийд хамаа бүхий засгийг тогтоож Ойн Урианхайд Бурхан Халдуны дархан орныг сахих хувь тохиол олгосон байна.

ЮАНЬ ГҮРЭН БОЛОН ТҮҮНИЙ ДАРААХ ҮЕИЙН УРИАНХАЙ ТҮМЭН

Умард Юанийн зургаан түмний нэг болох Урианхай түмэн болон Мин улсын үеийн Доён харуул нь адил бус хоёр ухагдахуун мөн. Урианхай түмний тухай мэдээлэл “Даян хааны зургаан түмний магтаал”-д нэлээд тодорхой тэмдэглэгдэж буй.

“qulan g]riyes]n-i idej]. qulan görügesün-i idejü.
quluhan tarbahan-iyar julma kij]. quluḡar tarbaḡan-iyar zulum-a kijü.
qulahaici degerem-]n darahul bolohsan .qulaḡayiçi degerem-ün daruḡul boluḡsan.
quduh-un usun-i harhahci uriyangqant] qudtuḡ-un usun-i ḡarḡaḡsan uriyanḡqai tümen”²².
“Хулан гөрөөсийг идэж
Хулгар тарвагаар зулам хийж

¹⁹ 《史集》(Судрын чуулган), 第一卷第一分册, P.202.

²⁰ 《史集》(Судрын чуулган), 第一卷第一册, p.202-203

²¹ 《史集》(Судрын чуулган), 第一卷第二分册, P.373.

²² 《蒙古古代文学精品百篇》(Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой), [蒙]达木丁苏荣编, 内蒙古人民出版社, 1979年9月, P.635.

Хулгайч дээрмийн даруул болсон
Худгийн усыг гаргасан Урианхай түмэн”.

Энд би энэ аман түүхийн материалыг сийрүүлэн бичсэн гол зорилго нь Мин улсын ба Умард Юанийн үеийн Урианхай түмний гол бүрэлдэхүүн нь ойн иргэд, тэдний хоол хүнс ба хувцас хунарын эрэлт нь бүр агнал амьдралаас эрэлтэй гэснийг гэрчлэх гэсэн юм. Тэдний гол үүрэг хариуцлага нь Бурхан Халдуны дархан цаазат орныг сахих явдал мөн гэдэг нь сэжиглэшгүй үнэн юм. Урианхай түмэн худгийн ус малтах гэдэг нь бараг Чингис хаан баруунш дайлсан замд үүссэн бололтой. “Чингис хааны их тахилгын бичиг”-т Урианхай түмнийг магтахдаа:

“Алс холыг дайлах хахир өвлийн аян дайнд
Адисхан туламтай хатуу мөсийг хэмлэж явахад
Ангийн чинь олзны борцноос идэж
Арайхийж малтсан худгийн чинь усаар ундаалж ...
Албат Урианхай түмэн минь”²³ гэжээ.

Юань улсын эхний үед Говийн арын цагийн байдал ороо бусгаа байж Хубилай болон умардын мөргөлдөөний төв болжээ. Гэвч дархан цаазат орон нь хоёр талаараа бүр хамгаалах ёстой дээдсийн онгод тул Чингис хааны “Бурхан Халдунд буй Дархан цаазат орныг хамгаалагтун, үүрд дайтахгүй” гэсэн Их засгийн нэгэн өгүүлбэр Урианхай аймгийг дайны хөлөөс зайлуулж, тэд ороо бусгаа үед мөн өсөн үржих ховор тохиолыг олж бүхий л Юань улсын үед Ойн Урианхай аймаг нь үймээн самуунд өртөлгүй дархан цаазат орныг хамгаалан сууж байжээ. Юань улсын үед говийн арын олонх аймгууд нь Аригбөхийн харьяат байсан бөгөөд Урианхай аймаг нь яриангүй “Тулуй улс” (“Судрын чуулган”-д “Их улс” буюу “Үлөг улс” гэдэг)-ын харьяат мөн. Аригбөхийн ахмад хүү Ёхбор (yubuhueг玉不忽儿) баруун замын алтан ургийн урвалганд оролцож Аригбөхийн угсаа төрлийнхөн Юань улсаас салан тусгаарлахад хүрсэн бөгөөд Хубилай хааны гучин онд их жанжин Тогтохыг томилон Киргиз болон Туваг цохиулан Киргиз, Тувагийн ойн таван аймгийг хураан эзэлжээ. Юань улсын үед Урианхайн зарим мянганьг Хянган давааны өмнө талын Доён (duoyan 朵颜) уулын орчимд нүүлгэж суурьшуулан малжих ба ан агнаж амьдардаг байжээ. Эдгээр урианхайчууд даруй Доён (duoyan 朵颜) гурван харуулын Урианхайчуудтай угсаа гарвал нэгтэй гэж үзэж болохоор байна.

Умард Юанийн эхэн үед улс төрийн хувьсгал өөрчлөлт нь Монголын нийгэмд лут их хувьсал өөрчлөлтийг авчирсан байна. Монголын зүүн бүс нутагт их бага аймаг угсаа шинээр нийлэлдэн бүрэлдэх явцад Ойн Урианхай аймгаар гол болсон уулын ойн иргэд түмний хэсэг аймаг угсаа нь (талын аймаг Сүлдэст ч оролцсон

²³ 《蒙古古代文学精品百篇》，P.243.

байж мэднэ) эцэстээ “Урианхай түмэн” болон бүрэлдэж аажмаар бузгайран хүчирхэгжжээ.

Хамаа бүхий түүхэн материалыг үндэслэвэл, Даян хаан амьд байхдаа Урианхай түмнийг бүрэн эзэмшилдээ оруулж чадсангүй харин түүний омбол хүү Бодь Алаг хаан 20 жил дайтаж байж Урианхай түмнийг бүрмөсөн эзэлж чадсан бөгөөд бусад таван түмэнд салгаж захируулжээ.

1. Даян хаан Монголын баруун гарын гурван түмнийг хураах Далан тэргүүний дайнд Урианхай түмэн Монголын зүүн гарын гурван түмний хувиар оролцсон бөгөөд Даян хааны тохируулга ёсоор Ордос түмэнтэй эсэргүүцэлдэж, “Даян хаан зарлиг болруун: Ордос бол Чингис хааны найман цагаан ордыг сахигч сайн тавилантан, харин Урианхай бол Чингис хааны алтан шарилыг хадгалагч эрхэм заяатан. Тэд хутгалдаж, Хорчин ба Авга аймаг жигүүр бологтун.” Энд Урианхай түмэн зүүн гарын бусад түмэдтэй хамтаар байлдаанд оролцож байснаас тэд Даян хааны Монголыг нэгтгэх үйлсийг дэмжиж байсан гэдгийг үзэж харж болох бөгөөд Урианхай аймаг нь барууны томоохон түмэн болох Ордостой хаггалдаж байснаас тухайн үеийн тэдний цэрэг дайны хүчирхэг байдлыг мэдэж болно.
2. Даян хаан баруун гурван түмнийг хураасны дараа өөрийн ноёрхлыг бэхжүүлэхийн төлөө хуваан захируулах дүрмийг хэрэгжүүлж, өөрийн шууд харьяаны Монголын эл аймгийг үр хүүхдэдээ хуваан өгч, гагц “Урианхай түмэн” энэ удаагийн хуваан захирахад өртсөнгүй. Үүнээс мэдэж болох нь Урианхай түмэн тухайн үеийн хагас тусгаар байдалд оршиж мөн бусад отгийн зайсан, ноён захиран эзэмших байдалтай байжээ.
3. Бодь хааны үеийн “Урианхай түмний урвалгаан” гэдэг нь үнэндээ “Даян хааны хуваан захируулах” болон эл түмний “нутаг хуваан малжих”-тай салж болшгүй харьцаатай юм. Хамаг түрүүнд алтан ургийнхан ба Урианхай түмний ноёрхогч бүлгийн хоорондох улс төрийн ашиг тусын мөргөлдөөн болно. Нэгэнт өдөр ирэхүйеэ хүчирхэгжиж байгаа алтан ургийнхан Урианхай түмэн үргэлжлэн бусдын овгийн ноёдын захиргаанд байхыг хүлээн зөвшөөрч чадахаа больсон явдал нь Урианхай түмний урвалгааны үндсэн шалтгаан болсон байна. Говийн арыг эзлэн суусан халх түмний хүн мал өсөж газар хуваан малжихад Урианхай түмний бэлчээр ба агналын талбар өдөр ирэхүй жижгэрч хоёр талын мөргөлдөөний ужиг болжээ.
4. 1524-1544 оны 20 жилийн хугацаанд монголын зүүн, баруун гарын эл түмэн холбоолон Урианхай түмнийг довтолж Урианхай (duoyanwuliangha朵颜兀良哈) түмний гол бүрэлдэхүүн болох “Шар Урианхай” болон “Улаан малгайт Урианхай” нар эцэстээ тэдэнд эзлэгдэн хураагджээ.

ДОЁН УРИАНХАЙ

Мин улсын эхний үед Говийн өмнөх хэсэг Монгол аймгууд арга буюу Мин улсад бууж өгсний дараа Мингийн төрөөс харуулын захиргаа хуваан харьяа

газрыг захирчээ. Хун-У (hongwu洪武)-ын 22-р он (1389)-д Ляо-янгийн (liaoyang 辽阳) хуваарь мужийн Кайюань (kaiyuan开元) чөлгийн хязгаар дахь Доён уулын орчмын Урианхай зэрэг Монголын эл аймгууд Мин улсад бууж өгсний дараа Мин улс тус газарт нь Доён гурван харуул хувааж (бас Урианхай гурван харуул буюу Үжээд гурван харуул гэдэг) эл аймгийг төвхнүүлжээ. Тайнинн 泰宁, Доён朵颜, Фүюй福余 гурван харуулын дарга түшмэлийг томилж, өөрийн харьяат олныг нь захируулсан²⁴ талаар Мин улсын түүхэн материалд тус явдлын тухай тодорхой тэмдэглэсэн байдаг. Эх Доён өндөр уул нь одоогийн Жалайд хошууны хойд хэсгийн Чоол голын (chaoerhe朝尔河) эхэнд буй.

Доён гэдэг үг нь “duoyan”-аас хувирч ирсэн, duo уан гэдэг нь монгол үг. Энэ нь бөөгийн шашин үг хэллэг билээ (doying)²⁵. Юань улсын үеийн Доён өндрийн Урианхай мянган даруй энэ газарт амьдарч байжээ. Үүнээс мэдэж болох нь Доён уул орчим нь уулаас Урианхай аймгийн эзэмшил нутаг байжээ. Хун-У-гийн (hongwu洪武) 22-р оны таван сард бууж өгөөд удаагүй байсан Доён харуулын хэрэг мэдэгч Тогучар Мин гүрэнд өргөсөн бичигтээ:

“Бидний Урианхай нар ойн иргэд. Улсын эзэн, дэлхийн буянт Чингис хааны үеэс эх Доён өндөр, Сумлан өндөр зэрэг газар усаар чөлөөтэй зорчиж өнөө хүртэл эс салж, ан гөрөөс, харцгай ирвэс зэргийг Шанду нийслэлд он он нийлүүлж байв. Одоо дэлхийн буянт Мин гүрний хааны зарлигаар Ляо-янд нийлүүлэх болжухуй. Ирэх очихын дээр ядуу зүдүү ардын өргөл барьцыг шууд ордонд олсон эсэхийг үл мэднэ. (qu去) Гуйчлах өргөл барьцыг шууд Бейпинд (beiping北平) өргөсүгэй.”²⁶

Үүнээс үзэхэд, Кайюань чөлгө (kaiyuanlu开元路) нь угаасаа Юань улсын үеийн Урианхай аймгийн оршин суух ба агнуурын талбар мөн гэдэг нь сэжиглэшгүй ажээ. Тухайн үед дээрх Доёнын гурван харуулд хуваагдсан Монгол аймаг нь өөрийн нэрийдэлтэй буюу аймгийн нэртэй байв. “У Бэйгийн ойллого” (wubeizhi武备志-) 227 дугаар ботийн оршилд “Умард угсааны тэмдэглэл” (Beishikao-北势考)-д тэмдэглэснийг үндэслэвэл Тайнин (taining泰宁) харуул (wangliu往流), Фүюй харуул (wozhu我著-), Доён харуул (wuliangan五两案) гэжээ. Ванлюй (wangliu往流) гэдэг нь даруй хятад түүхэн бичгийн (wangliu-罔留) монгол түүхэнд үргэлж тохиолддог Онгууд (unggirud~ unglirud)-ын авиачилсан

²⁴ 《明史》(Мин улсын түүх)卷328, 《朵颜三卫传》, 中华书局, 1974年。

²⁵ 在蒙古地方被称作“abu ahula”父亲山, “e:y ahula”母亲山的地方不少。比如位于科右前旗阿里德尔苏木北部归流河西岸的“kili abu ahula”,位于其南部的小山当地人称作“e:y ahula”。因为该山南段有酷似乳房的两个小山包,因此当地人照它的形状命名该山为母亲山。再观察朵颜山顶的形状也如此,很有可能“额客多延温都儿”之名来源于此。Монгол оронд “Аав уул”, “Эж уул” гэдэг газар их олон байна. Жишээлбэл: Хорчин баруун гар нь өмнөд хошууны Алдар сум хойд хэсгийн Гүйлгэрийн голын баруун эрэгт хил “аав уул”, түүний өмнө талд орших жижиг уулыг “эж уул” гэж нэрлэдэг. Учир нь энэ уулын өвөр талд нь хөх шиг 2 бомбогорттой байдаг. Нутгийн олон түүний энэхүү онцлогийг үндэслэн эж уул гэж нэрлэсэн байдаг. (Эх Доён гэдэг өндөр нэрлэсний шалтгаан нь ийм байж магад).

²⁶ 明刻本(Мингийн сийлмэл бичиг)《涵芬楼秘籍》(Хан Фен Леугийн нууц тэмдэглэл)所录《华夷译语》(Huayiyuyu-гийн үгсийн орчуулга), 卷下。

орчуулга болно. Вожү (wozhu我著-) бол даруй (wuzhe兀者-) монголын түүхэн бичгийн Үжээд (Ijiyed)-ийн авиачилсан орчуулга болно. Wuliangan五两案 гэдэг нь “Урианхай” монгол түүхэн дээрх урианхай (uriyangqai)-н авиачилсан орчуулга болно.

Үүнээс мэдэж болох нь Доён гурван харуулын монголчууд нь адил нэгэн аймгаас үүсэлтэй биш, өөрийн үүсэл гаралтай юм. Урьдын эрдэмтэд Доён харуулын гарлын тухай нэлээд судалгаа хийж мөн судалгааны талаар олон жилийн турш судалжээ. Түүхэн материалын хязгаарлалаас шалтгаалж ойрын хэдэн жилд Доён харуулын тухай судалгаа зогсонги байдалд оржээ. Энэ байдалд чиглүүлэн өөр нэг талаас асуудалд хандаж урьдын хүмүүсийн судалгааны аргаас өөр үзэл баримтлал дэвшүүлэхийг зорьсон болно. Бидний судалгааны үзэл бодлыг бусад эрдэмтэн судлаачид цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

Юань улсын үеийн Ляодун (liaodong辽东) Ляоси (liaoxi辽西) орон нь тус Ляо-ян (liaoyang辽阳) хуваарь муж болон Жүн Шу (zhong shu) мужид харьяалагдаж байв. Юань улсын сүүлээр улс өдөр ирэхүйеэ доройтож Ляо-ян (辽阳) хуваарь мужийн байршил мөн тасралтгүй хувирч байжээ. Ляо-ян хуваарь мужийн өмнөд хэсгийг “Ляогийн газар” (liaodi 辽地) гэдэг байв. Ляогийн газар гэдэг нь “Гурван төрийн Ляо улсын түүхийн бодит тэмдэглэл”-д тэмдэглэснийг үндэслэвэл “Ляогийн газар нь зүүнш Ялу мөрнөөс эхлэн баруунш Шанхайгуань боомт (shanhaiguan山海关-) хүрч 1460 газар өмнөөс Лю Шун (lü shun旅顺) гарам, умарш Кай Юанийн хилд тулж 1070 газар” ажээ.

Юань улсын үед Данин (daninglu大宁路), Ляо-ян (liaoyanglu辽阳路), Гуаннин (guangninglu广宁路), Шэньян (shenyanglu沈阳路), Кайюань (kaiyuan开元路), Шуйдада (shuidadalu水达达路), Дуннин (dongninglu东宁路) чөлгө (1290 онд чөлгөг цогцлоож Гуулинд (gaojuli高句骊) буцаан захируулжээ) зэрэг долоон чөлгө²⁷, Ляо-ян зэрэг хуваарь мужид харьяалагджээ. Харин Тайнин (taining泰宁), Нинчан (ningchang宁昌), Цюаньнин (qiuanning全宁) гурван чөлгө нь Юань улсын үед Чингис хааны дүү Тэмүгэ Отчигины хойчис Ляо ван, Билгүүтэйн хойчис Гон ван, Гуаннин Ван (guang ning wang广宁王) болон Мухулайн харьяат Монголын таван аймаг (Монголын таван чөлгийн ноёд)-жалайр, хонгирайд, икирэс, уруд, мангуд зэрэг эл аймгийн ноёдын хойчисын харьяат газар ба Цахарын хойчисын хоёр мянган урианхай аймаг энд нутаглаж байжээ.

Юань улсын сүүлч буюу Ляо-Ян хуваарь мужийн өмнөд хэсэг нь Мухулай Го вангийн хойчисын харьяа нутаг байжээ. Сүүлчийн үеийн ноёрхогч нь Мухулай Го вангийн хойч Ляо-ян хуваарь мужийн зүүн гарын Чинсан (chengxiang丞相) Есбүх болно. Жижэн (zhizheng至政)-ийн 28 дугаар онд тэр шууд харьяа мужийн зүүн гарын Чинсан (chengxiang丞相) болон дэвшиж мөн л Кайюаньд сууж Ляо-ян хуваарь мужийн өмнөд хэсгийг захирч байжээ. Адилхан хугацаанд дээдсийн өргөмжлөлийг залгамжлан Ляо-ян хуваарь мужийн зүүн хэсэг ба дунд хэсгийг захиран эзэмшиж байсан өөр нэгэн ноёрхогч бол Юань улсын сүүлч Мин улсын

²⁷ 《元史》(yuanshi), 点校本地地理志, 1983年. P.1395. 谭其骧主编《中国历史地图集》中把中书省管辖的泰宁路、宁昌路划入了辽阳行省版图.

эхэн үеийн нэгэн үеийн нэрт жанжин Нагачу (nahachu纳哈出) болно. Тэр их цэрэг дайчлан Жиншанд (jinshan金山) хуарагнаж, Есбухтай хамжилцан Ляо-ян хуваарь мужийг сахиж Мин улсын цэрэгтэй дайсагнаж байжээ.

Нагачугийн (nahachu纳哈出) хэргэм зэрэгтэй Тайвэй, (太尉taiwei) Шу чинсан (shuchengxiang署丞相), Кайюань ванд (kaiyuanwang开元王) хүрч байжээ. Нагачу Тайпин (taiping太平) чөлөгө түмнээс гаралтай. “Мин улсын түүх”-д тэмдэглэснийг үндэслэвэл “Нагачу, Юань улсын үеийн хойчис, Тайпинг чөлөгөгийн (taipinglu 太平路) түмний харьяат. Тайзу (taizu太祖) Тайпинг чөлөгөгийн харьяатад бууж өгөөд нэрт сайдын хойчис хэмээн хүндэтгэн нэрлэв. Гэтэл тэрбээр Юанийг эс умартан умардад буцахыг санагалзав. Юань улс мөхсөний дараа Нагачу (jinshan金山) цэрэг тэжээж мал аж ахуйг үржүүлэв. Хаан олонтоо жуу бичиг буулгасанд эс хариулав. Ляодунгийн хязгаарт байн байн халдаж, Е ван (yewang叶旺) дийлэгдэв. Их цэрэг хүрсэнд бууж өгөв. Хайси хоу (haishihou海西侯) өргөмжлөгдөж, Фү Юдэ-г (fuyoude傅友德) дагаж Юньнаньд (yunnan云南) цэрэглэж, зам зуур эцэслэв. Хөвгүүн нь Цагаан. Шэньян Хоу-г (shenyanghou沈阳侯) халан өргөмжлөгдөж Ланьүйгийн (lanyu蓝玉) холбоотноор тодорч цаазлагдав”²⁸. Нагац “Жин шанд (jinshan金山) удаан сууж (одоогийн Ляохэгийн хойд эрэг), хорин түм гаруй цэрэгтэй, эд агуурс нь Юанийн эзнээс ч элбэг гурван хэсэгт хуваамуй. Юй Лин (qiyulin日榆林), Ян Жуан (qiyangzhuang日养鹅庄), Лун-аны (qilongan日龙安) Өтлийн голд Юань улсын хааны Тай-эй түшмэл байжээ. Албалах нь үгүй”²⁹. Нагачугийн тухайн үед удирдаж байсан монгол цэрэг нь даруй хорьт түмэн Урианхай нар болно.

Өлгө (shanyang山阳) түмний Урианхай аймгийн гарал хоёр буй. Нэг нь, Хачиуны аймгийн уугуул иргэд нь гурван бүлэг хүмүүсээр бүрэлдүүлж түүний нэг хэсэг нь Найман аймаг, бас нэг хэсэг нь Урианхайгаас бусад монголын эл саланги бутархай аймаг болно. Хожим Чингис хаан түүнийг авга Даридай Отчигинд харьяат мянганыг бас Хачиуны улсад нийлүүлэн суулгав. Хоёр нь, Наяаны урвалгаа дарагдсаны дараа Хубилай хаан Жиюаний (zhiyuan至元) гучдугаар онд баруун хойдын уравсан ноёдын харьяат Киргиз, Үсүд, Хангинас гурван аймгийн олныг Доён уул зэрэг газарт суурьшуулан Доён Урианхай бүрэлджээ.

“Судрын чуулган”-д “Мухулай бол Жалайр аймгийн хүн. Нэр хүнд бүхий бусад овгийн түшмэл бөгөөд гавьяа зүтгэл ихтэй болохоор Чингис хаан Жалайр аймгийн бүх цэргийг түүнд тушаан өгч захируулжээ. Тэр Жалайр аймгаа мянгатад хувааж мэдүүлэв [Чингис хаанд]. Жалайр аймаг нь нийт гурван мянган. Чингис хаан түүнийг Хятадтай хиллэж Хархун Жидүнд томилж суулгахуйд хятад хүмүүс түүнийг Го ван хэмээн дуудвай. Утга нь эрхэм дээдэс болой. Хожим нь Чингис хаан түүнийг Го ванд өргөмжилж, түүний үр хойчис Хүве хэргэмийг залгамжлав. Мухулайн харьяат Монголын зүүн гарын түмэнд бараг зургаан түм

²⁸ 《明史》(mingshi)第一百二十九卷, 列传第十七。P.3799

²⁹ 查继佐(chajizuo):《罪惟录》(Ялт түшмэлийн тэмдэглэл) 列传第八卷中.《纳哈出传》,《四部丛刊》三编本。P.1020

хоёр мянган хүнтэй байв. Тэдний дунд Урианхай хүнээр удирдуулсан мянган зургаа байв. Тус тус Есбух тайшийн мянган, түүний ач хүү Хархуна Жобуны мянган, Сүбэдэй ноёны хөвгүүн Гөгцийн мянган, Оточ ноёны Ойн Урианхай мянган, Цагархайн харьяат хоёр Урианхай мянган. Үүнд Оточийн Ойн Урианхай мянган үе улиран Бурхан Халдуны дархан цаазат орныг сахин суухаас бусад таван мянган нь Хянганы давааны Өлх түмэнд багталцаж суурьшиж маллаж байв. Учир нь Мухулайн харьяат нутаг нь “Хятадтай зах нийлсэн Хархун Жидүн” байж хятад иргэдтэй ойрхон байдаг болохоор хятад иргэд тэднийг Го ван гэж дуудаж байжээ. Гэвч Мухулайн харьяат зургаан Урианхай хүнээр удирдуулсан мянган нь бүр цул Урианхай хүмүүсээр бүрэлдсэн явдал биш ажээ.

Умард Юанийн эхэн үед умард Юань улсын их цэрэг дийлдэж ухрахад Монголын зүүн хэсгийн байдал мөн ороо бусгаа болжээ. Юань Хуй Зунг (huizong 元惠宗) аав хүү хоёр Инчанфү-д (yingchangfu 应昌府) ухран суусны дараа Чюаньнин чөлгийг бэхжүүлэхийн төлөө цэргээ яаралтай татаж Ляо Янг (liaoyang 辽阳) хуваарь мужийн Уруд, Мангуд, Икирэс гурван аймгийг Чюаньнин чөлгөөд туслуулахаар татаж Хонгирад аймагтай хожмын “Чюаньнингийн дөрвөн аймаг”-ийг бүрдүүлжээ. Тэгээд Ляо Ян хуваарь мужийн Кай Юан, Шэньян, Ляо Ян гурван чөлгийн Урианхай аймаг нь Ляо Ян хуваарь мужийн өмнөд хэсэг тусгаарлагдсан байдалтай орших болжээ.

Хун-У (hongwu 洪武)-ийн 2 дугаар оны (1369) 4 сараас Мин улсын засаг “Нагачу Ляо Янд цэрэг хуарагнуулан сууж хязгаарт аюул болж буй” гэж мэдсэнээс “Хун-У-гийн 20 оны цагаан сар (1387 (-)) Жу Юань Жанг (zhuyuanzhang 朱元璋) сая жинхэнээр зуу бичиг буулган Фэн Шэн (fengsheng 冯胜)-ээр дайлан дагуулах их жанжин болгон Чин Хоу Гүнг Фү Ю Де (fuyoude 傅友德) зүүн гарын дэд жанжин, Юн Чан хоу (yongchanghou 永昌侯) Лан Иуй бээр баруун гарын жанжин болгож, Нан Сян хоуг (nanxionghou 南雄侯) Жао Юн (zhaoyong 赵庸), Дин Юнь хоу (dingyanhou 定远侯) Ван Би (wangbi 王弼) бээр зүүн гарын туслагч жанжин, Дун Чуан хоу (dongchuanhou 东川侯), Ху Хай (huhai 胡海) У Дин хоу (wudinghou 武定侯) Го Ин (guoying 郭英) бээр баруун гарын туслагч жанжин болгож умарш Нагачуг дайлаар мордож зуны зургаан сард Нагачу хоёр талын цэргийн хэлэлцээрт оролцохоор Лан Ю (lanyu 蓝玉) тохируулсан “Хун Мэн Ян (hongmenyan 鸿门宴) хурим”-д оролцож мэхлэгдэн баривчлагдах хүртэл Нагачу Мин улстай бүтэн хорин жил эсэргүүцэлдэж билээ. Ляо Ян хуваарь мужийн халхавчаа алдсан умард Юаний төр нь Хун У-ын 21 дүгээр онд Мин улсын цэргийн гэнэдүүлэн дайралтад учирч Монголын их хаан Төгстөмөр Буйр нуурт (buyuerhai 捕鱼儿海-) Мин улсын жанжин Лан Юйд (lanyu) дийлэгдэж ухрах зам зуураа Есүдэрт хорлогдсон билээ. Хүнд хэцүү цэрэг дайны ялагдал нь Хянганы давааны зүүн биеийн Монголын энэ аймгуудыг түшиг тулгуургүй ганцаардмал байдалд оруулжээ. Ляо Ян хуваарь мужийн хил доторх Нагачугийн хуучин харьяат Урианхай аймгийн үлдэгдэл хэсгүүд зөвхөн Мин улсад бууж өгөх л болжээ. Хунг У (hongwu) 22 дугаар он (1389) Доён уулын орчмын сахиул Урианхай нарын үлдэгдэл хэсгүүд нь тэдний ахлагч Тогучарын

дагуулга дор Мин улсад бууж өгөв. Мингийн засгаас уг оронд нь Доён харуул байршуулж, толгойлогчийг Доён харуулын хэрэг мэдэгч ноёноор томилж “Аймгаа дагуулан, төвхнөн малжтугай” гэжээ. Доён харуулын монголчууд өөрсдийгөө Урианхай аймаг гэдгийн шалтгаан энэ билээ.

ДҮГНЭЛТ

Урианхайн гарвал үүслийг судлахад монгол түүхийн бичиг, үе үеийн түүхэн судар, түүхэн тэмдэглэлийг ашиглах нь бодит байдалд нийцэх юм. Монгол үндэстэн дотроо урианхай аймаг нь 1300 илүү жилийн түүхтэй хамгийн эртний аймаг билээ.

Ляо гүрний үед арын Урианхай нь хоёр янзаар түүх сурвалжид тэмдэглэгдсэн бөгөөд нэг нь улс, нөгөө нь урианхай аймаг байсан нь “Ляо улсын бичиг”-т Ляо улсын харьяат улсын ордны болон аймгийн нэрийдлийг нарийн тэмдэглэсэнд тулгуурлан ялгаж болох юм. Уг бичигт тэмдэглэгдсэнээр урианхай аймаг нь Ляо улсын үед нэлээд томоохон болж, Волянхай улсын ба Ванянхай аймаг гэж хоёр хэсэг хуваагджээ. Волянхай улс нь Ляо гүрэнтэй харьяат улсын харьцаатай байхад Ванянхай аймаг нь Ляо гүрэнтэй нь нэг удаагийн дайн байлдааны үед холбогдсоноос өөр харилцаа холбоогүй байжээ. Ванянхай гэдэг нь бол газрын нэрээр бас тэмдэглэгдсэн бөгөөд энэ нь монголын өндөрлөгийн баруун хойдын нэгэн аймаг угсаа буюу ойн урианхай болно.

Их Монгол улсын үеийн Урианхайн түүхийг “Судрын чуулган”-д харьцангуй бүрэн бүтэн тэмдэглэсэн байна. “Судрын чуулган”-ыг үндэслэвэл тухайн үеийн Урианхай нь “Ойн Урианхайчууд” болон “Дарлигин Урианхайчууд” гэсэн хоёр хэсгээс бүрэлдэнэ. Судрын чуулганы тэмдэглэл нь хэдийгээр хожмын эрдэмтдийн эргэлзэлд өртсөн боловч “Ляо улсын түүх”-д тэмдэглэсэнтэй яв цав нийцсэн байдаг.

Тиймээс “Судрын чуулган”-д тэмдэглэсэн Урианхай аймгийн түүх нь үнэн бодит зүйл хэмээн үзэж байна. Мөн Рашид Ад Дины тэмдэглэлд Дарлигин монгол гаралтай урианхай аймгаас алдарт хоёр хүн гарсан нь Сүбэдэй, Зэлмэ нар болно. Сүбэдэйн дээдэс үе үе улиран Бурхан Халдунд нутаглаж байсан тухай “Монголын түүхэн тэмдэглэл”-ийн 29-р ботид, Зэлмэ-ийн эцэг Жарчиудай урианхай аймгийн хүн бөгөөд “Бурхан Халдунд нутаглаж, Чингис хааны эцэг Есүхэйтэй анд, Чингис хааныг мэндлэхэд хүрэлцэн ирж баяр хүргэж булган манцуй бэлэглэв” Юань улсын түүх”-н 29-р ботид тэмдэглэснийг үндэслэвэл Сүбэдэй, Зэлмэ Бурхан Халдуны Урианхай аймгийн хүн болох нь гарцаагүй ажээ. Бурхан Халдунд нутаглаж байсан Урианхай аймаг нь Их Монгол улс байгуулагдсаны дараа Зэлмийн, Сүбэдэйн мянган болж алтан ургийн шинэ эздээ даган шинэ эзэмшилд нүүдэллэж тэдний оронд Ойн урианхай нь Баргужин төхөмд нутагладаг байснаа тэднийг орлож Бурхан Халдунд нүүдэллэн иржээ. Ойн урианхайдаар дээдсийн орныг сахиулах болсон нь Бурхан Халдуны дархан орныг сахих тохиол олгосон.

Урианхай аймгийн эх гарал нь нэгд Хачиун аймгийн уугуул иргэд Найман аймаг болон Урианхайн зарим саланги бутархай аймаг нийлж, улмаар Наяагийн урвалт дарагдсаны дараа урвасан ноёдын харьяат Киргиз, Үсүд, Хангинас гурван аймгийн олныг Доён уулын газарт суурьшуулан Доён Урианхай бүрэлджээ.

Номзүй

1. 《辽史》，中华书局，1974年10月第一版
 2. 《多桑蒙古史》，冯承钧译，上海书店出版社，2001年6月第一版，P.158~159
 3. 《说文解字》，[汉]许慎撰，中华书局影印，1963年12月第一版。
 4. 《康熙字典》，[清]张玉书主编，天津古籍出版社，1995年9月第一版。
 5. 《王力古汉语字典》，中华书局，2000年6月第一版。
 6. 《元史》，中华书局，1976年4月，
 7. 蒙兀儿史记》，屠寄著，线装本影印版，第二十九卷，《者勒蔑传》。
 8. 《史集》，拉施德著，余大钧译，商务印书馆，1983年1月第一版，第一卷，第一分册，P.255。
 9. 《蒙古秘史》，四部丛刊三编本，第221节。
 10. 《蒙古古代文学精品百篇》，[蒙]达木丁苏荣 编，内蒙古人民出版社，1979年9月，P.635。
 11. 《蒙古古代文学精品百篇》，p.243。
 12. 《明史》，中华书局，1974年。
 13. 孙毓修等编纂：明刻本《涵芬楼秘籍》商务印书官据该藏本影印出版 1926年，所录《华夷译语》，卷下。
 14. 《元史》点校本地理志，1983年。谭其骧主编《中国历史地图集》中把中书省管辖的泰宁路、宁昌路划入了辽阳行省版图。
 15. 查继佐：《罪惟录》商务印书官据该藏本影印出版 1936年，列传第八卷中，《纳哈出传》，《四部丛刊》三编本。
1. “Минь улсын түүх” Zhonghua бичгийн товчоо. 1974 оны 10-р сарын 1 дүгээр хэвлэл, 1-р боть / Пайзугуи тэмдэглэл/
 2. Ляо улсын түүх. 6-р боть. Хүснэгт 7.
 3. “Дуньсун Монголын түүх” Ting qiqin орчуулав. Шанхайн номын дэлгүүрийн хэвлэлийн хороо. 2001 оны 6-р сард 1-р удаа хэвлэв. p.158-159
 4. “Хятад үсгийн тайлбар” [Хань] Ши Шин (Han Xu Shen) зохиов. Дунхи (Tonghua) бичгийн товчоог нь зураг авианы хэвлэл, 1960 оны 12-р сарын нэгдүгээр хэвлэл. (“Энх-Амгалангийн үсгийн толь” Чинь Ging, Жань Zhang, Жань Yi Shu голлон найруулав. Тяньжин эртний бичгийн хэвлэлийн хороо. 1995 оны 9-р сард анхны хэвлэл. Wang Li Gu-ийн Хятад хэлний толь бичгийн хороо. 2000 оны 6-р сарын анхны хэвлэл)
 5. Ляо улсын түүх. 116 дугаар боть. *Үгсийн тайлбар.*
 6. Ляо улсын түүх. 46 дугаар боть. *Ноёдын тэмдэглэл*
 7. Ляо улсын түүх. 6 дугаар боть. *Мучунгийн уг тэмдэглэл.*
 8. Ляо улсын түүх. 27 дугаар боть. *Тияан Цүве хаан Яйлиүй Яан Си.*

9. Ляо улсын түүх. 36 дугаар боть. *Цэрэг хуягийн тэмдэглэл*. Харьяат улсын цэргийн зурвас.
10. Ляо улсын түүх. *Цияан Да Шиний харгуулан хянасан дэвтэр*.
11. Ляо улсын түүх. 69 дүгээр боть. *辽史*, 第六十九卷, 《嚙族表》。
12. Юань улсын түүх. Зүн Хуа бичгийн хороо. 1976 оны 4 сар. Нэгдүгээр барын дахин хэвлэл. 121 дүгээр боть. Сүбэдэйн намтар.
13. Монголын түүхийн тэмдэглэл. Ту Жий зохиов. Үдмэл барын сүүдэр хэвлэл. 29 дүгээр боть. Зэлмийн намтар.
14. Судрын чуулган. Рашид Ад Дин зохиов. Иүй Да Жиюун орчуулав. Шанг Эү хэвлэлийн хороо. 1983 оны 1 сар. Нэгдүгээр бар. I боть. 1 дүгээр дэвтэр. х. 225.
15. Судрын чуулган. I боть. Хоёрдугаар дэвтэр. х. 379.
16. Монголын түүхийн тэмдэглэл. 28 дугаар боть. Цуурхайн намтар.
17. Монголын Нууц Товчоо. 221 дүгээр зүйл
18. Судрын чуулган. I боть. Нэгдүгээр дэвтэр. х. 202.
19. Судрын чуулган. I боть. Нэгдүгээр дэвтэр. х. 202.
20. Судрын чуулган. I боть. Хоёрдугаар дэвтэр. х. 373.
21. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив. (Монгол). Ц.Дамдинсүрэн. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1979 оны 9 сар. х. 635.
22. Монголын уран зохиолын дээд бичиг оршив. х. 243.
23. Мин улсын түүх. 328 дугаар боть. *Доён гурван харуулын намтар*. Жүн Хуа бичгийн хороо. 1974 он
24. Монгол оронд “Аав уул”, “Ээж уул” гэдэг газар их олон байна. Жишээлбэл: Хорчин баруун гар нь өмнөд хошууны Алдар сум хойд хэсгийн Гүйлгэрийн голын баруун эрэгт хил “аав уул”, түүний өмнө талд орших жижиг уулыг “ээж уул” гэж нэрлэдэг. Учир нь энэ уулын өвөр талд нь хөх шиг 2 бомбогортой байдаг. Нутгийн олон түүний энэхүү онцлогийг үндэслэн ээж уул гэж нэрлэсэн байдаг. (Эх Доён гэдэг өндөр нэрлэсний шалтгаан нь ийм байж магад).
25. Мингийн сийлмэл барын “Хан Фен Леугийн нууц тэмдэглэл”-д тэмдэглэсэн “Хува Эйгийн үгсийн орчуулга” доорд боть.
26. Юань улсын түүх. Цохлон харгуулсан дэвтрийн газар зүйн ойллого. 1983 он. Дан Чи Сияанг голлон найруулсан “Дундад улсын түүхэн газрын зургийн түүвэр”
27. Мин улсын түүх”-ийн 129-р боть, “Намтар цадиг”-ын 17.
28. Зэ Жий Цүве. Ялт түшмэдийн тэмдэглэл, 8 дугаар боть.

Abstract

Uriankhai Tribe is an Tribe and ethnic that has had a great influence on the development of Mongolian history. The Tribe became quite large during the Liao Dynasty, and was divided into two parts: the Wolanggai State (-wolanggai 斡朗改) and the Wanyanggai Tribe (wanianggai 嗚娘改-). The two provinces that were called Urianhai and Oin Urianhai (huaiyin 槐因-) from Mongolia during the Yuan Dynasty were divided into the East and West Five Nations after the Yuan Dynasty. From the reign of Kublai Khan to the thirtieth year of the Yuan Dynasty, five Tribes including

Tuva and the Uriankhai of the Forest, which had been under the control of Togtobukh, migrated to the southern part of the Khyanggan Pass. In the early Ming Dynasty, the Uriankhai Three Guards (duoyanwuliangha朵颜兀良哈) who had lived south of the Khyanggan, rose up and conquered the entire middle and upper basin of the Liao River (liaohe辽河), and after the Tsakhar people led the three eastern tribes to the east, the Uriankhai Three Guards (wulianghasanwei兀良哈三卫) were divided into the three eastern tribes, and some Uriankhai people moved west and supported the Golden Khan of Tumed. Among the five counties of Zost, one of the six Mongolian councils of the internal government of the Qing Dynasty, three Kharchin counties and the nobility of Tumed's left-hand county have a Mongolian Uriankhai tribe. Many historical records mention that their ancestor was Zelme, one of the four dogs of Genghis Khan of the Great Mongol Empire. I don't long-wind about this. The article mainly tried to define the origins of the Uriankhai tribe.